



20.18 оны 08 сарын 24-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 61, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 сарын 03-ны Лхагва гарагийн 10:00 цагт Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх Мираж ресторанд хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 09 сарын 13-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2018 оны 08 сарын 27-ны өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2018 оны 08 сарын 29 болон 09 сарын 13-ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материал, баримт бичгийг 2018 оны 09 сарын 03-ны өдрийн дотор брокер дилерийн компаниудад хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралт, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 3 дугаар хавсралт, компанийн хувьцаа хуваах төслийг 4 дүгээр хавсралт, компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төслийг 5 дугаар хавсралт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай:

Комиссын дарга:	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Н.Сүрэнрагчаа
Гишүүд:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
	Захиргаа, хүний нөөцийн газрын захирал	Ч.Солонго



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.18 оны 08 сарын 24-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Зургаа. Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Н.Сүрэнрагчаа-д даалгасугай.

Долоо. Саналын хуудсаар санал авах сүүлчийн өдрийг 2018 оны 09 сарын 28-ны өдрөөр тогтоож, саналын хуудсын агуулга, загварыг 7 дугаар хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 8 дугаар хавсралтаар баталсугай.

ТУЗ-ийн ДАРГА:

“ГОВЬ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН




Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 08 сарын 24-ний өдрийн хурлын
26-р тогтоолын 1 дүгээр хавсралт



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:


1. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД БЭЛТГЭХ,
ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажлын утга	Эцсийн хугацаа	Хариуцах эзэн
А. ХУРЛЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ			
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалыг бэлтгэх, хэвлүүлэх ажлыг зохион байгуулах	VIII/31	М.Сэлэнгэ
Б. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ			
1	“Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх	VIII/27	М.Сэлэнгэ
2	Хурлын зар мэдээ гаргах, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх	VIII/29, IX/13	М.Сэлэнгэ
3	Хурлын танхимын бэлтгэл, зохион байгуулалт, тоног төхөөрөмжөөр хангах, хурлын хэвийн явцыг хангах	X/03	Ч.Солонго
4	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд танилцуулах илтгэлийг бэлдэх	IX/26	М.Сэлэнгэ
5	Саналын хуудсыг хэвлүүлэх	IX/26	М.Сэлэнгэ
6	Хурлын тэмдэглэл хөтлөх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангуулах	IX/28	Ч.Солонго

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 09 сарын 28-ний өдрийн хурлын
46-р тогтоолын 3 дүгээр хавсралт



**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ
БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2018 оны 09 сарын 03-ны өдрөөс эхлэн 09 сарын 28-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээрээ ирж танилцаж болно.
2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Говь ХК-ийн хувьцаа хуваах төсөл
 - Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах төсөл
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материал
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах тогтоолын төсөл
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан



“ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ХУВААХ ТӨСӨЛ

1.1 ҮНДЭСЛЭЛ:

Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 52 дүгээр зүйл болон 63-р зүйлд тус тус заасны дагуу 2018 оны 10 сарын 03-ны өдөр хуралдсан “Говь” ХК-ийн эрх барих дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар энэхүү “Говь” ХК-ийн Хувьцаа хуваах төслийг хэрэгжүүлэх бүрэн үндэслэл бүрдсэн болно.

Монгол улсын хөрөнгийн бирж дээрх “Говь” ХК-ийн нэгж хувьцааны үнэ сүүлийн 4 жилийн байдлаар дээд тал нь 35,180 төгрөг хүрсэн бөгөөд нэгж хувьцааны үнийн дүнгийн өсөлттэй нөхцөл байдал нь компанийн хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны эргэлт чөлөөтэй арилжаалах нөхцөл байдлыг бууруулж байна гэж компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс үзэж байна. Учир нь сүүлийн 4 жилийн хугацаанд компанийн нийт гаргасан хувьцааны 4% нь хөрөнгийн зах зээл дээр идэвхтэй арилжигдсан байна.

Өмнө жилүүдэд хувьцаагаа хуваасан компаниудын хувьцааны арилжааны идэвхийг “Говь” ХК-ийн хамт доорх хүснэгтэд харуулав:

АПУ ХК, Сүү ХК болон Говь ХК-ийн хувьцааны 2015-2018 оны хооронд арилжигдсан ширхэг

Компани	2015	2016	2017	2018	Нийт	2016/06/01- 2016/06/10 хүртэлх
“АПУ” ХК	270,989.00	2,067,727.00	13,769,498.22	7,033,599.00	23,141,813.22	380,301.0
“Сүү” ХК	1,737.00	1,699,250.00	4,514,727.00	1,412,454.00	7,628,168.00	1,572.0
“Говь” ХК	43,427.00	59,302.00	140,047.00	73,117.00	315,893.00	

“АПУ” ХК болон “Сүү” ХК нь 2016 оны 6 сард хувьцаагаа 10 ширхэг болон 1,000 ширхэгт хуваах хүртэл буюу 2016/06/10-ны өдөр хүртэл 380,301 ширхэг болон 1,572 ширхэг арилжигдсан нь 2016 онд тухайн компанийн нийт арилжигдсан ширхгийн 18.4% болон 0.1% -ийг тус тус бүрдүүлсэн байна. Хувьцаа хуваасны дараагийн жил буюу 2017 оны арилжигдсан тоо ширхэг 2016 онтой харьцуулахад 6.7 болон 2.7 дахин их байна. Өмнө нь хувьцаа хувааж байсан компаниудын арилжааны идэвхи нь хувьцаа хуваасны дараа нэмэгдсэн байгаа нь зах зээл дээрх хувьцааны эргэлт болон чөлөөтэй арилжаалах нөхцөл байдал сайжирсныг харуулж байна.

Дээрх компаниудын хувьцаа хуваасны дараах хувьцааны үнэлгээг дор харуулав.

1. “АПУ” ХК (APU)

1.1. Хувьцаа хуваахын өмнөх болон дараах үеийн зах зээлийн үзүүлэлт /2016/06/20 өдөр компанийн нэгж хувьцаа 10 дахин хуваагдсан/

№	Агуулга	Хувьцаа хуваахаас өмнө	Хувьцаа хуваасны дараа			
		2016/06/10	2016/06/21	2016/12/28	2017/12/28	2018/08/24
1	Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ /төг/	3,970	477.0	396.22	716.7	584.67
2	Нийт зарласан хувьцааны тоо /шир/	106,418,155	1,064,181,553	1,064,181,553	1,064,181,553	1,064,181,553
3	Зах зээлийн үнэлгээ /сая төг/	422,480	507,615	421,650	762,699	617,342

2. “СҮҮ” ХК (SUU)

2.1. Хувьцаа хуваахын өмнөх үеийн зах зээлийн үзүүлэлт /2016/06/20 өдөр компанийн нэгж хувьцаа 1,000 дахин хуваагдсан/

№	Агуулга	Хувьцаа хуваахаас өмнө	Хувьцаа хуваасны дараа			
		2016/06/10	2016/06/21	2016/12/28	2017/12/28	2018/08/24
1	Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ /төг/	145,000	161.88	128.16	255.01	217.63
2	Нийт зарласан хувьцааны тоо /шир/	344,000	344,000,000	344,000,000	344,000,000	344,000,000
3	Зах зээлийн үнэлгээ /сая төг/	49,880	55,687	44,087	87,723	74,865

1.2 ЗОРИЛГО

Компанийн нэгж хувьцааг 100 дахин хувааж, нэгж хувьцааны зах зээл дээрх үнэлгээг бууруулснаар компанийн хувьцааны хөрөнгийн зах зээл дээрх чөлөөт хөрвөх хувь/Free float/-г нэмэгдүүлэн олон хувьцаа эзэмшигчтэй болох боломжийг бүрдүүлж мөн хувьцааны зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэн хөрвөх чадварыг сайжруулан улмаар компанийн зах зээлийн үнэлгээг өсгөх, цаашлаад хувьцааны төвлөрлийг бууруулах томоохон ач холбогдолтой үйл ажиллагаа болно.

1.3 ШИЙДВЭР

“Говь” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор компанийн хувьцааны хөрөнгийн зах зээл дэх арилжааг идэвхжүүлэх зорилгоор нэгж хувьцааг 100 ширхэгт хуваахаар шийдвэрлэсэн.

1.4 АЧ ХОЛБОГДОЛ:

Компанийн хувьцааг хувааснаар компанид дараах ач холбогдол үүснэ. Үүнд:

- Хувьцааны хөрвөх чадвар сайжирна.
- Хувьцааны хөрвөх чадвар сайжирснаар жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж хувьцааны арилжаа идэвхжиж, компанийн үнэлгээ шинээр тогтсоноор хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнэ өснө.
- Хувьцааны ханш хөрөнгийн бирж дээр хямд үнээр арилжаалагдах нөхцөл бүрдэнэ.
- Компанийн үйл ажиллагаа өмнөх үеэс илүү нээлттэй олон нийтэд ил тод болж, компанийн хувьд шинээр хөрөнгө татах боломж үүснэ.
- Компанийн зах зээлийн үнэлгээ өсөх, зах зээлийн үнэлгээ өсөхийн хэрээр брэндийн нэр хүнд өснө.
- Хувьцааны үнэ хямд болсноор олон жижиг хувьцаа эзэмшигчтэй болох боломж бүрдэнэ.
- Нэмж хувьцаа гаргахад санал болгох үнийг багаар тогтоох боломжийг олгоно.

ХОЁР. ХУВЬЦАА ХУВААХ ТООЦООЛОЛ

2.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор компанийн нэгж хувьцааг 100 ширхэгт хуваахаар шийдвэрлэсэн.

2.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрт үндэслэн хувьцааг хувааснаар "Говь" ХК-ийн гаргасан хувьцаа дараах тооцооллын дагуу нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 780,112,500 ширхэг хувьцаа болж өөрчлөгдөнө.

	Хуваахаас өмнө	Хуваасны дараа
Нийт гаргасан хувьцаа	7,801,125 ширхэг	780,112,500 ширхэг
Нэг хувьцааны нэрлэсэн үнэ	100 төгрөг	1 төгрөг
Хувьцаат капиталын дүн	780,112,500 төгрөг	780,112,500 төгрөг
Хаалтын ханш - Бүртгэлийн өдрөөр /2018-09-13/		
Зах зээлийн үнэлгээ /2018-09-13/		

ГУРАВ. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ТЭДГЭЭРТ ҮҮСЭХ АЧ ХОЛБОГДОЛ

3.1 Компани хувьцаа хуваах тухай асуудлын хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн "Компанийн тухай" хуулийн 52 дугаар зүйл болон 63 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

3.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ хүргүүлж хувьцаа хуваах асуудлыг **шийдвэрлүүлнэ.**

3.3 Компанийн хувьцааг хуваах тухай "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарч, Улсын бүртгэлд холбогдох бүртгэлийг хийлгэснээр хувьцааг хуваах үйл ажиллагаа хэрэгжинэ.

3.4 Хувьцаа хуваах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан компанийн хувьцааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцааны арилжааг түр зогсоож болно.

3.5 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д хувьцааг хуваах бүртгэлийн ажил дуусгавар болсноор компанийн хувьцааны арилжаа хэвийн явагдах боломжтой болно.

3.6 Хувьцаа хуваах үйл ажиллагаатай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс авч хэрэгжүүлэх ямарваа нэгэн эрх, үүрэг үүсэхгүй бөгөөд энэхүү төслийн 3.5-д зааснаар арилжаа хэвийн явагдаж эхэлсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг биржийн арилжаагаар чөлөөтэй арилжих эрх нь нээлттэй болно.

3.7 Компанийн хувьцааг хувааснаар хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад дараах давуу тал, ая холбогдол үүснэ. Үүнд:

3.7.1 Хувьцаа эзэмшигчдийн 1 ширхэг хувьцаа бүр 100 ширхэг болж хувьцааны тоо хэмжээ нэмэгдэн үнэ шинэчлэн тогтсоноор хөрвөх чадвар нэмэгдэх.

3.7.2 Хувьцааны хөрөнгийн зах зээл дээрх арилжааны идэвх нэмэгдсэнээр компанийн үнэлгээг зах зээлийн жишгээр бодитоор үнэлэгдэх боломж олгож хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнэ өсөх боломжтой.

3.7.3 Компанийн засаглал илүү сайжрах нөхцөл бүрдэж, улмаар хөрөнгө оруулагчдын хүртэх хөрөнгийн өгөөж нэмэгдэнэ.

ДӨРӨВ. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДУУСГАВАР БОЛГОХ

4.1. Компанийн хувьцаа хуваах төслийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулан шийдвэр гаргуулснаар компанийн хувьцааг хуваах нөхцөл бүрдэнэ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д болон Санхүүгийн Зохицуулах Хороонд танилцуулан зөвшөөрөл авч хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна.

Үүний дараагаар "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК дахь үнэт цаасны хадгаламжийн мэдээлэл болон компанийн дүрэмд өөрчлөлт оруулж Улсын бүртгэлд бүртгүүлснээр уг үйл ажиллагаа дуусгавар болно.

4.2. Хувьцаа хуваахтай холбоотой үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх

Хувьцаа хуваах, хувьцаа хуваахтай холбоотой дүрэмд орох өөрчлөлттэй холбоотой асуудлыг "Говь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал нь Компанийн тухай хуулийн 53.1-д заасантай холбоогүй байна. Иймд компани нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам батлах шаардлагагүй гэж үзэж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 08 сарын 24-ний өдрийн хурлын
26-р тогтоолын 5 дүгээр хавсралт

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт
Гурав. Компанийн хувьцаа ба хувь нийлүүлсэн хөрөнгө		
1	3.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 7,801,125 (долоон сая найман зуун нэг мянга зуун хорин төгрөг) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Компанийн хувь хөрөнгийн хэмжээ 780,112,500 төгрөг байна.	3.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 780,112,500 (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун ширхэг) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Компанийн хувь хөрөнгийн хэмжээ 780,112,500 төгрөг байна.

Жич: Компанийн одоогийн дүрмийг 2018 оны 4 сарын 17-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар баталсан болно.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 3 минут
2. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
3. Хэлэлцэх асуудал:
 - 3.1 Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг танилцуулах
/Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа/ 10 минут
 - 3.2 Хувьцаа хуваахтай холбоотой компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг танилцуулах
/Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр/ 3 минут
4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт Хүн тус бүр 3 минут
5. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл: Хүн тус бүр 3 минут
6. Саналын хуудсаар санал авах 10 минут
7. Санал хураалтын дүнг нэгтгэх хооронд компанийн үйл ажиллагааны талаар танилцуулах
/Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа/ 10 минут
8. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах 5 минут
9. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал асуулгын дүнг тусган танилцуулж, төслийг батлуулах
/Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр/ 3 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 1 цаг 30 минут

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 08 сарын 24-ний өдрийн хурлын
26-р тогтоолын 7 дүгээр хавсралт

/Саналын хуудасны загвар/



MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ
ХУУДАС**

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 10:00 цагт Говь ХК-ийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр
Эзэмшиж буй хувьцааны тоо төрөл энгийн
Дансны дугаар Регистрийн дугаар

Батлах асуудлууд:	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1. Компанийн хувьцааг 1:100 хуваах саналыг батлах	☐	☐	☐
2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах	☐	☐	☐

2018 оны ... -р сарын ... -ны өдөр

Гарын үсэг

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

- Саналын хуудсыг дараах зааварын дагуу бөглөнө.
 - Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓), тагталзсан бол тагталзсан гэсэн нүдэнд (✓), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
 - Засварласан, багласан, (✓)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2018 оны 09 сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
- Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.



/Хэвлэл мэдээллийн эх/

ТТН2998 ± 2076357

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 10:00 цагт Говь ХК-ийн Төв дэлгүүрийн дэргэдэх Мираж ресторанд болох тул хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2018 оны 09 сарын 13-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2018 оны 09 сарын 03-ны өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах ТУЗ-ийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс өөрийн харилцдаг брокер, дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2018 оны 09 сарын 28-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын дарга Н.Сүрэнрагчаа
Утас: 7013-9977(1002)
Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ
Утас: 7013-9977(1193), 9411-8277
И-мэйл: selenge.m@gobi.mn

Говь ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, "Говь" ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 08 сарын 24-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:	Ч.Солонго – Захиргаа, хүний нөөцийн газрын захирал
Нарийн бичгийн дарга:	М.Болортуяа – Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд	Ц.Цэцэгбадам – Ахлах нягтлан бодогч
	Б.Уянга– Хөдөлмөрийн харилцаа хариуцсан албаны дарга

Хоёр. Тооллогын комисс (Ч.Солонго)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултанд тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Саналын хуудсыг хайрцагаар авах;
6. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
7. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

ТУЗ-ийн ДАРГА

ТУЗ-ийн ГИШҮҮД



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.18 оны 08 сарын 24-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН